

**2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДРИЙН ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧООС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 04 дүгээр сарын 14-ний “Баасан” гарагийн 12:00 цагаас өмнө e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцно.

Биелэлтийг ирүүлэхдээ үүрэг даалгавар бүрийн хэрэгжилтийн хувийг тодорхой бичиж ирүүлнэ үү.

Цэвэрлэгээний биелэлтийг ирүүлэхдээ цэвэрлэгээнд хамрагдсан ажилтан, албан хаагчдын тоо, цэвэрлэсэн талбайн хэмжээ болон хог хаягдлын хэмжээг тодорхой бичиж ирүүлэхийг анхаарна уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД		
1.	Нийслэлийн нутгийн захиргааны босоо удирдлагын тогтолцоотой байгууллагуудын төрийн захиргаа, төрийн үйлчилгээний хэдэн албан хаагч ажиллаж байгаа судалгаа, цалинг нэмэгдүүлэх санал боловсруулж танилцуулах.	ТЗУХ
2.	Хороодын Засаг дарга, хэсгийн ахлагч нарын цалинг нэмэгдүүлэх санал боловсруулж танилцуулах.	ТЗУХ
ИРГЭДИЙН ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД		
3.	Барилгын ажлын явцад гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, барилгын ажлын талбай түүний гаднах эрсдэл бүхий орчны аюулгүй байдлыг бүрдүүлэх, хяналт тавих, хөдөлмөрийн аюулгүй байдал, стандартын шаардлага, машин тоног, төхөөрөмжийн аюулгүй байдалд хяналт тавих ажлаа эрчимжүүлэх.	ТХҮХ
4.	Нийтийн эзэмшлийн гудамж талбай, хөшөө дурсгал, сандал, хүүхдийн тоглоомын талбай, зэрэг байгууламжуудын өнгө үзэмжийг сэргээх ажлуудаа эрчимжүүлэх.	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
5.	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын чиг үүрэг шилжсэнтэй холбогдуулан эрүүл, ахуй, хоол үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдлын чанар, стандартад онцгой анхаарч, хяналт тавьж ажиллах.	ТХҮХ, МЭТ
ЦАГ ҮЕИЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД		
6.	Түр худалдаа үйлчилгээ эрхлэх байршлын жагсаалт гаргаж, ажлыг зохион байгуулах	ТХҮХ, Худалдаа үйлчилгээг зохицуулах салбар зөвлөл
7.	Нийслэлийн хэмжээнд орон сууцны бодлого болон гэр хорооллыг орон сууцжуулах ажлуудаа эрчимжүүлэх.	ЗДТГ

8.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон Гэр бүл, хүүхдийн эрхийн хамгааллын талаар 14 хоног бүр дүүргийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнд нөхцөл байдлын танилцуулга хийх.	ХХҮХ, ГБХЗХХ
9.	“Хүүхдийн автобус”-нуудыг үйлчилгээнд нь шуурхай гаргаж, автобусны ашиглалт, техникийн шаардлага, стандартыг онцгой анхаарч, хүүхдүүдийг автобусаар тав тухтай, аюулгүй тээвэрлэх нөхцлийг бүрдүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах.	НХХ, Боловсролын хэлтэс, ХЦС
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
10.	Төгсөх ангийн сурагчдыг ЭЕШ-д амжилттай оролцох боломж нөхцлөөр хангах хүрээнд бэлтгэл ажлыг сайтар хангаж, сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	НХХ, Боловсролын хэлтэс, ХЦС
11.	Хаврын улирал эхэлж, хуурайшил бий болсонтой холбогдуулан ой хээрийн түймэр гарах эрсдэлтэй тул ажилтан, албан хаагч, иргэдэд мэдээ мэдээлэл хүргэн анхааруулах арга хэмжээ авч ажиллах	ОБХ, Хороод, ААНБ-ууд
12.	Цаг агаарын нөхцөл байдлын улмаас өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг цуглуулж, устгах ажлыг зохион байгуулж ажиллах	ТХҮХ, ХААТ, МЭТ